

## 2010 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД МОНГОЛ УЛС ГАДААДТАЙ ХАРИЛЦСАН ГОЛ ҮЙЛ ЯВДЛЫН ЖАГСААЛТ

- 2010.01.11 “Тайм” сэтгүүлийн 2009 оны “Байгаль орчны салбарын Баатар”, онцлох хүнээр тодорсон Түвд гаралтай Австралийн иргэн Доржээ Сан Монгол Улсын Ерөнхийлөгчид бараалхлаа. Монгол Улсын Ерөнхийлөгч түүнийг хүлээн авч уулзахдаа Монгол Улс дахь экологийн нөхцөл байдал, зарим бэрхшээлүүдийг шийдэх арга замын тухай санал солилцов.
- 2010.01.12-17 Монгол Улсын Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт тэргүүтэй төлөөлөгчид Канад Улсад ажлын айлчлал хийв. Д.Зоригт сайд Канадын Олон улсын худалдааны сайд С.Дейтэй уулзаж, харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцлоо.
- 2010.01.13 Монгол Улсын Гадаад харилцааны яам, Бүгд Найрамдах Чех Улсын Гадаад хэргийн яам хоорондын улс төрийн ээлжит 3 дугаар зөвлөлдөх уулзалт ГХЯ-нд боллоо. Чех Улсын Засгийн газар Хөгжлийн албан ёсны тусламж олгох цөөн орны тоонд манай улсыг цаашид ч хамруулж, үр өгөөжтэй төслүүд хэрэгжүүлэхээ энэ үеэр мэдэгдэв.
- 2010.01.16-17 Япон Улсын Токио хотноо болсон Зүүн Ази, Латин Америкийн хамтын ажиллагааны чуулга уулзалт (ФЕАЛАК)-ын Гадаад хэргийн сайд нарын 4 дүгээр уулзалтын үеэр Монгол Улс тус олон талт чуулга уулзалтын гишүүнээр батлагдаж, нэгдэн оров.
- 2010.01.18 Европын Холбоог төлөөлөн Бүгд Найрамдах Болгар Улсаас Монгол Улсад суугаа ЭСЯ-ны Хэргийг түр хамаарагч ноён К.Колев, Их Британийн Элчин сайд У.Диксон нар Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржид бараалхаж, ЕХ болон Их Британийн Засгийн газраас гаргасан мэдэгдлүүдийг гардуулав.
- 2010.01.21 Монгол Улс, Европын Холбооны хооронд Түншлэл, хамтын ажиллагааны Хэлэлцээр байгуулах эхний үеийн хэлэлцээ ГХЯ-нд амжилттай явагдав. Хэлэлцээний үеэр талууд Монгол Улс, ЕХ-ы харилцаа идэвхжин хөгжиж байгаад сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлж, хоёр талын хамтын ажиллагааг бүхий л салбарт өргөжүүлэх, шинэ агуулга хэлбэрээр баяжуулах энэхүү Хэлэлцээрт ихээхэн ач холбогдол өгч байгааг

- тэмдэглэлээ. Мөн Хэлэлцээний дараагийн үеийг Брюссель хотод хийх, аль болох ойрын хугацаанд Хэлэлцээрийг эцэслэхээр талууд тохирлоо.
- 2010.01.21 Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж манай улсад айлчилж байгаа ОХУ-ын Воронеж мужийн амбан захирагч, Монгол улстай хийх худалдаа, эдийн засгийн болон хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааг хариуцсан ОХУ-ын Ерөнхийлөгчийн тусгай төлөөлөгч А.В.Гордеевийг хүлээн авч уулзлаа.
- 2010.01.23 Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын / ШХАБ/ дэргэдэх Ажил хэргийн зөвлөлийн хуралдаан Улаанбаатар хотноо МҮХАҮТ-д болсон бөгөөд хуралдааны дараа төлөөлөгчдийг Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд хүлээн авч уулзав.
- 2010.01.28 Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтанд оролцохоор Швейцарийн Давос хотноо хүрэлцэн ирсэн Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж БНСУ-ын Ерөнхийлөгч Ли Мён Бак, Бельгийн угсаа залгамжлах ханхүү Филипп Брабант болон Зимбабве улсын Ерөнхий сайд М.Цювангерий нартай уулзаж ярилцсан юм.
- 2010.01.29 Давос хотноо Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтанд оролцож байгаа Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржид Канадын олон улсын худалдааны сайд ноён Питер ван Лон бараалхав.
- 2010.02.09 Гадаад харилцааны сайд Г.Занданшатар НҮБ-ын Дүрвэгсдийн Дээд Коммиссарын газрын Бээжин дэх Бүсийн Төлөөлөгч Верапонг Вонгваротайг хүлээн авч уулзан уг байгууллага болон Монгол Улсын Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны талаар санал солилцож, Монгол Улс Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай 1951 оны конвенц, уг конвенцийн 1967 оны нэмэлт протоколд нэгдэн орох асуудлаар ярилцав. Уулзалтын үеэр Бүсийн Төлөөлөгч ноён В.Верапонг НҮБ-ын ДДКГ-ын Бүсийн Төлөөлөгчийн газраас манай улсын цас зудны гамшигт өртсөн аймгуудын малчдад 20 мянган ам.долларын тусламж гардуулав.
- 2010.02.09 Монгол Улсаас ӨАБНУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Б.Алтангэрэл Өмнөд Африкийн Ерөнхийлөгч Жекоб Зумад Итгэмжлэх жуух бичгээ барив.

- 2010.02.09-10 Монгол Улсын Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Монгол-Оросын ЗГХК-ын Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны Дэд комиссын Монголын хэсгийн дарга Д.Цогтбаатар ОХУ-ын БНБуриад Улсын Ерөнхийлөгч В.В.Наговицыны урилгаар БНБуриад Улсад ажлын айлчлал хийв. Айлчлалын үеэр ОХУ-ын БНБуриад Улсын Ерөнхийлөгч В.В.Наговицын, БНБуриад Улсын Засгийн газрын даргын орлогч Б.Г.Бальжиров нартай уулзаж Монгол-Буриадын хамтын ажиллагааны асуудлуудыг хэлэлцсэн бөгөөд мөн энэ оны 7 дугаар сард ОХУ-ын БНБуриад Улсын Улаан-Үд хотноо болох “Дэлхийн Монгол туургатны” IV чуулганы бэлтгэл ажлын асуудлаар санал солилцов.
- 2010.02.11 Монгол Улсын Гадаад харилцааны яам, НҮБ-ын Хүн амын Сан хамтран “Санал солилцох уулзалт”-ыг ГХЯ-нд зохион байгуулав. Уулзалтын үеэр НҮБ-ын Хүн амын сангаас ойрын хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээ болон түүний бодит үр ашгийг нэмэгдүүлэх, түүнчлэн Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хүн амын Сантай хамтран хэрэгжүүлэх шинэ хөтөлбөрийг боловсруулахтай холбогдуулан Засгийн газар болон иргэний нийгэм хамтран ажиллах боломжийн талаар ярилцлаа.
- 2010.02.15 Монгол Улсаас Данийн Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Б.Энхмандах Данийн Цог жавхлант Хатан хаан II Маргретед Итгэмжлэх жуух бичгээ барив.
- 10.02.16 НҮБ-ын Вена дахь салбарын дэргэд суугаа Монгол Улсын Байнгын төлөөлөгчийн газар 2000 оны хоёрдугаар сард УИХ-аас баталсан Цөмийн зэвсгээс ангид байх тухай хуулийн 10 жилийн ойг тохиолдуулан “Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх гэрээг бэхжүүлэх нь: сорилт ба боломж бололцоо” сэдвээр дугуй ширээний хэлэлцүүлгийг НҮБ-ын байранд зохион байгуулав.
- 2010.02.24 Нью-Йорк хотноо ажлын айлчлал хийж буй ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Д.Цогтбаатар Хүмүүнлэгийн асуудал хариуцсан ЕНБД-ын орлогч Ж.Холмс, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ)-ийн Захирагч Х.Кларк, НҮБ-ын ЭСАГ-ын орлогч

- дарга Д.Титов нартай уулзаж, эрдэмтэн судлаач, төрийн бус байгууллагын төлөөлөл, Монгол Улсыг сонирхож судалдаг хүмүүст зориулан Монгол Улсын гадаад бодлогын талаар яриа хийв.
- 2010.02.25 Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр Азадын Баатарцогт, Лхамсүрэнгийн Жавзмаа, Батцэнгэлийн Энх-Амгалан нарыг Монгол Улсаас ОХУ-ын Эрхүү, Улаан-Үд, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотод суух Ерөнхий консулуудаар томиллов.
- 2010.02.24-25 ГХЯ, НҮБ-ын Үйлдвэр хөгжлийн байгууллага (ЮНИДО)-тай хамтран “Монгол Улсын үйлдвэржилтийн бодлого” сэдэвт семинар, хэлэлцүүлгийг Улаанбаатар хотноо зохион байгуулав.
- 2010.02.25 Монгол Улсын Гадаад харилцааны дэд сайд Б.Болор Украин Улсын Элчин сайд Юрии Костенког Итгэмжлэх жуух бичгээ барьсантай нь холбогдуулан хүлээн авч уулзав.
- 2010.02.26 Монгол Улс, АНУ-ын Гадаад хэргийн яамд хоорондын улс төрийн зөвлөлдөх ээлжит уулзалт АНУ-ын Вашингтон хотноо амжилттай болж өнгөрөв. Энэ удаагийн уулзалтад Монголын талыг ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Д.Цогтбаатар, Америкийн талыг АНУ-ын Төрийн туслах нарийн бичгийн дарга Курт Кэмбэл нар тэргүүлэн оролцов.
- 2010.03.05 Япон Улсын Засгийн газар “өвсний үндэс” буцалтгүй тусламжийн хүрээнд 200 мянган ам.долларын тусламж үзүүлэх тухай гэрээнд Онцгой байдлын Ерөнхий газрын дарга, тэргүүн комиссар Ц.Амгаланбаяр гарын үсэг зурав. Түүнчлэн японы тал “Төслийн бус буцалтгүй тусламж”-ийн хуримтлалын сангаас нийт 500 мянган ам.долларыг зудын бэрхшээлийг даван туулахад зориулан зарцуулахаар шийдвэрлэсэнээ мэдэгдлээ.
- 2010.03.08-09 Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд анхны ажлын айлчлалаа Бүгд Найрамдах Австри Улсаас эхэллээ. Авлигатай тэмцэх хууль эрх зүйн орчныг сайжруулах, хуурамч эм бэлдмэлийг гадаадаас оруулахгүй байх холбогдох байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, Мансууруулах бодисын ургацын тархалтыг тогтооход шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, арга зүйн чиглэлээр НҮБ-тай хамтран ажиллах саналуудыг Ерөнхий сайд

- С.Батболд тавилаа. Энэ саналыг НҮБ хүлээн авч хамтран хэрэгжүүлэхээр тохиролцов.
- 2010.03.09 Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын (ЕАБХАБ) Ерөнхий нарийн бичгийн дарга Марк Перрин де Бришамботой уулзав.
- 2010.03.09 Монгол Улсыг хорт хавдартай тэмцэх Азийн бүсийн жишиг төв болголоо. Ерөнхий сайд С.Батболдын айлчлалын хүрээнд Олон улсын атомын энергийн агентлагийн Ерөнхий захирлын үүрэг гүйцэтгэгч бөгөөд Удирдлагын газрын дарга Дэвид Уоллер бараалхлаа. Уулзалтын үеэр Олон улсын атомын энергийн агентлагаас Монгол Улсыг хорт хавдартай тэмцэх Азийн бүсийн жишиг төвөөр шалгаруулсныг Дэвид Уоллер албан ёсоор мэдэгдэж баяр хүргэв.
- 2010.03.09 Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд Бүгд Найрамдах Австри Улсад хийж байгаа айлчлалынхаа хүрээнд тус улсын Холбооны канцлер Вернер Файманнтай хоёр талын уулзалт хийлээ. Эдгээр нь дулааны цахилгаан станцад нүүрсний утааг механик болон химийн аргаар шүүдэг Австрийн туршлагыг Монголд нэвтрүүлэх, Улаанбаатар хотод хог боловсруулж дулаан гаргах үйлдвэр барих, Улаанбаатар хотын цэвэр, бохир усны хоолойг шинэчлэх шуудуугүй технологи нэвтрүүлэх, Монгол Улсын Хавдар судлалын үндэсний төвийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, усалгаатай газар тариалангийн загвар аж ахуй байгуулах зэрэг төсөл хэрэгжүүлэх чиглэлээр ажиллах тухай тохиролцоо байв.
- 2010.03.10 Ерөнхий сайд С.Батболд НҮБ-ын Үйлдвэр хөгжлийн байгууллагын Ерөнхий захирлын үүрэг гүйцэтгэгч Ё.Урамото нарын хийсэн уулзалтын үеэр хоёр тал Монгол Улс, ЮНИДО-гийн 2006 онд байгуулсан Техникийн хамтын ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг бүрдүүлэх чиглэлээр идэвхтэй хамтран ажиллахаар санал нэгдэв.
- 2010.03.11 Байгалийн гамшгийн улмаас хүнд нөхцөлд байгаа малчдад зориулж “Дэлхийн зөн” олон улсын байгууллага 500 мянган ам долларын тусламж үзүүлэх болсоноо тус байгууллагын Зүүн бүсийн

- захирал, хатагтай Д.Дюпа Монгол Улсын Шадар сайд М.Энхболдтой уулзахдаа мэдэгдэв.
- 10.03.10-12 Ерөнхий сайд С.Батболд Унгар улсад албан ёсны айлчлал хийв. Ерөнхий сайд нарын хэлэлцээний хүрээнд Унгар улсад суугаа монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах, Улаанбаатарын инженерийн шугам сүлжээг шинэчлэх, геофизикийн хамтарсан хүрээлэн байгуулах, боловсрол, соёл шинжлэх ухааны хамтын ажиллагааг хөгжүүлэх, хоёр орны бизнес эрхлэгчдийн хамтарсан зөвлөл байгуулах, 25 сая ам.долларын хүүгүй зээлийн хэрэгжилтийг түргэтгэх зэрэг асуудлыг ярилцан шийдвэрлэхээр боллоо.
- 2010.03.12 Ерөнхий сайд С.Батболд Будапештийн “Алтан түлхүүр”-ийг гардан авлаа. Энэ үеэр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Г.Мөнхбаяр, Будапешт хотын дарга Д.Габор нар усны чиглэлийн боловсон хүчин бэлтгэх, БиокOMBИНАТ орчим үерийн усны далан барих, техник эдийн засгийнх нь үндэслэлийг хийх, соёлын өвийг хамгаалах, иргэдийн хурлын ажиллагааг идэвхижүүлэх тухай хамтын ажиллагааны Санамж бичигт гарын үсэг зурав.
- 2010.03.12 НҮБ-ын Үйлдвэр хөгжлийн байгууллага (ЮНИДО)-ын Бээжин дэх Төлөөлөгчийн газар (Монголын асуудлыг хариуцсан)-ын Байнгын төлөөлөгч ноён Эдвард Кларенс-Смит Гадаад харилцааны дэд сайд Б.Болорт Итгэмжлэх захидлаа гардуулав.
- 2010.03.18 Монгол Улс Европын Холбоотой байгуулах Түншлэл, хамтын ажиллагааны Хэлэлцээр (ТХАХ)-ийн 2 дугаар шатны хэлэлцээ Брюссель хотноо амжилттай болж өнгөрлөө. ЕХ-ны тал Монгол Улстай харилцах 2011-2013 оны Дунд хугацааны баримжаалсан хөтөлбөрөө баталж, үүндээ Монгол Улсад дээрх хугацаанд нийт 15 сая еврогийн тусламж үзүүлэх, тусламжаа Хөдөө аж ахуйн салбарын мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн боловсролын тогтолцоог дэмжих, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэхэд туслах ерөнхий шийдвэр гаргаад буйг хэлэлцээний үеэр Монголын талд албан ёсоор мэдэгдэв. 2007-2010 оны Дунд хугацааны баримжаалсан хөтөлбөрийн санхүүжилтээс үлдсэн 4 сая еврог ЕК-ын тал мөн

- манай улсын жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, Европын стандартыг Монголд нутагшуулах чиглэлд зарцуулах манай саналыг дэмжихээ илэрхийлэв. Ийнхүү ЕХ манай улсад 2010-2013 оны хооронд нийт 19 сая Еврогийн тусламж үзүүлэхээр болж байна.
- 2010.03.18 Монгол Улсаас Норвегийн Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Б. Энхмандах Норвегийн Цог жавхланта Хаан V Харалдад Итгэмжлэх жуух бичгээ барив.
- 2010.03.24 Монгол Улсын ГХЯ, Бүгд Найрамдах Турк Улсын Гадаад хэргийн яамд хоорондын ээлжит Зөвлөлдөх уулзалт Улаанбаатар хотноо болж, худалдаа, эдийн засгийн салбарт хамтын ажиллагааг эрчимжүүлэхээр тохиролцов.
- 2010.03.24 Монгол Улс, БНСУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 20 жилийн ойг тохиолдуулан хоёр улсын Ерөнхийлөгчид баярын захилгааны утас солилцов.
- 2010.03.24 Япон улсын иргэд 30 хоногийн хугацаагаар Монгол Улсад визгүй зорчих тухай Монгол Улсын Засгийн газрын шийдвэрийг Япон улсын Засгийн газарт мэдэгдсэн Гадаад харилцааны яамны төлөөний ноот бичгийг Монгол Улсын ГХ-ны сайд Г.Занданшатар Япон улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Т.Кидокород гардуулан өглөө.
- 2010.03.25 Монгол Улсад 15 сая еврогийн санхүүжилт хийхээр шийдвэрлэв. Монгол Улс, Европын Холбооны хооронд байгуулах Түншлэл, хамтын ажиллагааны Хэлэлцээрийн хоёр дахь шатны хэлэлцээний үеэр Европын Комисс Монгол Улстай харилцах 2011-2013 оны Дунд хугацааны баримжаалсан хөтөлбөрөө баталж, Монгол Улсад дээрх хугацаанд нийт 15 сая еврогийн санхүүжилтийг хоёр үндсэн чиглэлд буюу хөдөө орон нутгийн иргэдийн хөгжил, Европын Холбооны стандарт, хэм хэмжээг Монгол Улсад нэвтрүүлэх зорилтын хүрээнд албан хаагчдын чадавхийг бэхжүүлэхэд зарцуулах аж.
- 2010.03.25 Канадын Парламент дахь Канад-Монголын Найрамдлын бүлгийн дарга Сенатор Жозеф Дей, Бүлгийн зарим гишүүд Монгол Улсаас Канад улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Т.Залаа-Уулыг гэргийн хамт Сенатын Ордонд хүлээн авч уулзав.

- 2010.03.26 Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд БНЧУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Вацлав Йилекийг хүлээн авч уулзлаа. В.Йилек Монгол Улсад нүүрлээд байгаа байгалийн гамшгийг хохирол багатай давахад зориулж БНЧУ-ын Засгийн газраас 4 сая кроны тусламж үзүүлэх болсныг уламжлав.
- 2010.03.26 Ерөнхий сайд ХБНГУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Пиус Фишерийг хүлээн авч уулзлаа. П.Фишер Монгол Улсад учирсан байгалийн давагдашгүй хүчин зүйлийг гэтлэн давахад зориулж ХБНГУ-ын Засгийн газраас 100 000 /нэг зуун мянга/ еврогийн тусламжийг Германы Дэлхийн зөн (World vision) ТББ-аар дамжуулан үзүүлэх болсныг уламжлав.
- 2010.03.30 Монгол, Хятадын Засгийн газар хоорондын эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны комиссын ажлын хэсгийн хуралдаан ГХЯ-нд болов. Хоёр тал энэхүү хуралдаанаар өнгөрсөн онд болсон ЗГХК-ын 11 дүгээр хуралдаанаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг дүгнэхийг зэрэгцээ цаашид хоёр талын хооронд явагдаж буй худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаантай холбогдсон гол гол асуудлаар өргөн хүрээнд санал солилцов.
- 2010.04.05 Монгол Улсын Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Монгол-Оросын ЗГХК-ын Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны Дэд комиссын Монголын хэсгийн дарга Д.Цогтбаатарын урилгаар энэ сарын 5-9-ны өдрүүдэд ОХУ-ын БН Буриад улсын Эдийн засгийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч дарга Александр Евгеньевич Чепик айлчлав.
- 2010.04.06 Монгол Улсын гадаад харилцааг эдийн засагжуулах хөтөлбөрийн хүрээнд Гадаад харилцааны яам, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам болон Монгол Улсаас ОХУ, БНХАУ, БНСУ, Япон улсуудад суугаа Элчин сайд нарын хамтарсан уулзалтыг ГХЯ-ны санаачилгаар Улаанбаатар хотноо зохион байгуулав.
- 2010.04.06-08 Монгол Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Г.Занданшатарын урилгаар Бүгд

- 2010.04.08 Найрамдах Португал Улсын Гадаад хэргийн сайд Луй Амадо Монгол Улсад албан ёсны айлчлал хийв. Монгол Улс, БНСУ-ын хооронд байгуулсан “Иргэний болон худалдааны хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Гэрээ”-ний Батламж жуух бичгийг солилцов.
- 2010.04.08 Монгол Улсаас Финланд Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Б.Энхмандах Финланд Улсын Ерөнхийлөгч, Хатагтай Тарья Каарина Халоненд Итгэмжлэх жуух бичгээ барив.
- 2010.04.10-12 Монгол Улсын Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Цогтбаатар Кувейт Улсын Гадаад хэргийн дэд сайд Халид С. Аль-Жараллагийн урилгаар Кувейт Улсад ажлын айлчлал хийв. ТНБД Д.Цогтбаатар айлчлалын үеэр Кувейт Улсын Ерөнхий сайдын орлогч бөгөөд Гадаад хэргийн сайд Шейх Мухаммед Сабах Аль-Сабах-тай уулзаж хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа болон олон улсын тавцан дахь харилцан сонирхсон асуудлаар санал солилцож, Монгол Улсад айлчлахыг урьсан Гадаад харилцааны сайд Г.Занданшатарын урилгыг гардуулав.
- 2010.04.12 Монгол, Италийн хооронд дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ойг тэмдэглэх хүрээнд Монгол Улсад айлчилж буй Италийн эдийн засгийн хөгжлийн дэд сайд А.Урсог Гадаад харилцааны сайд Г.Занданшатар хүлээн авч уулзаж, хоёр орны харилцаа, түүний дотор хоёр талын эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудлаар санал солилцлоо.
- 2010.04.15 Гадаад харилцааг эдийн засагжуулах хөтөлбөрийн хүрээнд Гадаад харилцааны яам, Улаанбаатар хотын захиргааны хооронд 2010-2012 онд хамтран ажиллах тухай Санамж бичигт Гадаад харилцааны сайд Г.Занданшатар, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Г.Мөнхбаяр нар гарын үсэг зурав.
- 2010.04.16 Туркийн Истамбул хотноо энэ оны 6 дугаар сарын 7-ний өдөр Евроазийн аюулгүй байдал, эдийн засгийн хамтын ажиллагааны асуудлаар Гадаад харилцааны сайд нарын уулзалтын урилгыг Казакстаны Элчин сайд Орман Каримович

- Нурбаев , Туркийн Элчин сайд Ахмет Асим Арар нар Гадаад харилцааны сайд Г.Занданшатарт биечлэн гардуулж өглөө.
- 2010.04.23 Польш, Болгар, Чех, Словак, Унгар, Румын улсуудтай дипломат харилцаа тогтоосны 60 жилийн түүхэн тэмдэглэлт баярын арга хэмжээнд оролцож буй Румын, Польшийн Элчин сайдуудыг Гадаад харилцааны сайд Г.Занданшатар хүлээн авч уулзлаа.
- 2010.04.25-28 ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Д.Цогтбаатарын урилгаар Японы Гадаад хэргийн яамны Ази, Номхон далайн газрын дарга А.Сайки Монгол Улсад айлчлав.ТНБД Д.Цогтбаатар А.Сайки-тай хоёр талын өргөтгөсөн уулзалт хийв.
- 2010.04.27 Гадаад харилцааны сайд Г.Занданшатар, Швейцарийн холбооны улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Блэйз Года-г хүлээн авч уулзлаа. Элчин сайд Б.Года нь Монгол Улсад дөрөв дэх удаагаа ирж ажиллаж байгаа, хоёр орны хамтын ажиллагааг хөгжүүлэх үйлсэд идэвхи гарган ажиллаж байгаа хүн юм.
- 2010.04.28 Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж БНХАУ-д хийж буй төрийн айлчлалынхаа үеэр Бээжин хотноо Монгол-Хятадын бизнес форумыг нээж хэлсэн үгэндээ Монгол-Хятадын худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааг улам өргөжүүлэн хөгжүүлэх, зам тээвэр, хил гааль, хорио цээрийн нөхцлийг сайжруулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх талаар тэмдэглэв.
- 2010.04.28 “Унгарын соёлын сан”-гийн ордонд Монгол, Унгарын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойн баярын арга хэмжээг зохион байгуулав.
- 2010.04.30 “Цөмийн зэвсэггүй бүсүүд ба Монгол Улс” хэмээх нэртэй олон улсын бага хурал НҮБ-ын Төв байранд болж эдгээр улсууд сүүлийн 5 жилд явуулж ирсэн үйл ажиллагаагаа дүгнэж, цаашдын хамтын ажиллагаагаа улам бэхжүүлж, шинэ бүс байгуулах явдлыг дэмжиж байгаагаа илэрхийлэв.
- 2010.05.03 Монгол Улс, Франц улсын Гадаад хэргийн яамдын улс төр, худалдаа, эдийн засгийн Зөвлөлдөх уулзалт ГХЯ-нд амжилттай явагдав.

- 2010.05.04 Монгол Улсын Гадаад харилцааны сайд Г.Занданшатар, Япон улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Т.Кидокоро , Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын Улаанбаатар дахь Төлөөлөгчийн газрын дарга Ю.Ишида нар Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар нийт 1 тэрбум 3 сая иенийн үнийн дүн бүхий “Цэнгэг усны нөөц, биологийн төрөл зүйлийн төв”, “Хүний нөөцийг хөгжүүлэх тэтгэлэг” гэсэн 2 төслийг хэрэгжүүлэх тухай хоёр Засгийн газар хооронд солилцох ноот бичиг, тусламжийн хэлэлцээрүүдэд гарын үсэг зурав.
- 2010.05.10 Монгол Улсын Шадар сайд М.Энхболд БНХАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Юй Хунг өдөр хүлээн авч уулзав. 2010 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр Баруун хойд Хятадын Цинхай мужид 7.1 магнитудын хүчтэй газар хөдөлж, 2200 гаруй хүн амь үрэгдэж, 100 000 хүн орон гэргүй болсон билээ. Монгол Улсын Засгийн газар энэхүү байгалийн гамшгийн хор хохирлыг арилгахад зориулж БНХАУ-ын Засгийн газарт 50 000 ам.долларын буцалтгүй тусламж үзүүлэхээр шийдсэн бөгөөд Монгол Улсын шадар сайд тусламжийг гардуулан өглөө.
- 2010.05.13-19 БНСУ-ын Инчён хотноо хуралдсан НҮБ-ын Ази, Номхон далайн Эдийн засаг, нийгмийн комиссын 66 дугаар чуулган ажлаа өндөрлөлөө. Чуулганд Монгол Улсаас НҮБ-ын АНДЭЗНК-т суугаа Байнгын төлөөлөгч Л.Дашпүрэв тэргүүтэй төлөөлөгчид оролцож, Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Засгийн газраас эдийн засаг, нийгмийн салбарт баримталж буй бодлого, явуулж буй үйл ажиллагаа, тулгарч буй бэрхшээлийн талаар танилцуулав.
- 2010.05.14 Монгол Улс Европын Холбоотой байгуулах Түншлэл, хамтын ажиллагааны Хэлэлцээрийн гурав дахь шатны хэлэлцээ Гадаад харилцааны яаманд амжилттай боллоо. Хэлэлцээг Монголын талаас Гадаад харилцааны дэд сайд Б.Болор, Европын Холбооны талаас Еврпын Комиссын Монголыг хариуцсан хэлтсийн дарга Ф.Жессен нар тус тус тэргүүлэв. Мөн хэлэлцээнд Улаанбаатарт суугаа

- Европын Холбооны гишүүн орнуудын ДТГ-ын тэргүүн нар оролцлоо.
- 2010.05.19 Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд, Бүгд Найрамдах Чех Улсын Засгийн газрын дарга Ян Фишер нар Улаанбаатар хотноо уулзаж, хоёр талын харилцааны асуудлаар хэлэлцээ хийв. Талууд Хамтарсан хороо нь хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чухал механизм болохыг тэмдэглэв. Талууд худалдаа, хөрөнгө оруулалтын эрх зүйн таатай орчин бүрдүүлэхэд хамтран ажиллахаар тохиров.
- 2010.05.19 Монгол Улсын Гадаад харилцааны сайд Г.Занданшатар ХБНГУ-ын Холбооны Гадаад хэргийн сайд Г.Вестервелле-гийн урилгаар Герман Улсад хийж буй албан ёсны айлчлал хийв.
- 2010.05.19-20 Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболдын урилгаар Бүгд Найрамдах Чех Улсын Засгийн газрын дарга, ноён Ян Фишер Монгол Улсад айлчлав. Албан ёсны хэлэлцээний дараа Монгол Улсын БСШУЯ, БНЧУ-ын Боловсрол, залуучууд, биеийн тамирын яам хооронд 2010-2013 онд боловсрол, шинжлэх ухааны салбар болон залуучуудын асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр, Монгол Улсын БСШУЯ, БНЧУ-ын Соёлын яам хооронд 2010-2012 онд Соёлын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрт Монголын талаас БСШУ-ны сайд Ё.Отгонбаяр, Чехийн талаас Элчин сайд Вацлав Йилек нар гарын үсэг зурав.
- 2010.05.24 Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд Канад Улсын Төрийн албаны зөвлөлийн дарга Мария Баррадос, Канад Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Анна Биолик тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа.
- 2010.05.27 Монгол Улс ба Доминиканы Бүгд Найрамдах Улс найрсаг харилцаа, хамтын ажиллагааг улс төр, эдийн засаг, хүмүүнлэгийн болон бусад салбарт хөгжүүлэх хоёр талын эрмэлзлийг удирдлага болгон дипломат харилцаа тогтоохоор шийдвэрлэж, хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоох тухай хамтарсан албан мэдээнд Нью-Йорк хотноо гарын үсэг зурав. Ийнхүү Доминиканы Бүгд Найрамдах Улс нь манай улсын дипломат харилцаа тогтоосон 150 дахь орон боллоо.

- 2010.05.31 Европын Холбооны (ЕХ) Европын Комиссын шийдвэрээр зудын гамшигт нэрвэгдсэн малчин өрхүүдэд хүмүүнлэгийн тусламж үзүүлэн, амьжиргааг нь дэмжих зорилгоор Монгол Улсад 2 сая еврогийн тусламж үзүүлэхээр болжээ. Энэхүү тусламж нь зудад нэрвэгдсэн малчин өрхүүдийн хүнсний аюулгүй байдлыг сайжруулах, амьжиргааг дэмжих, эрүүл мэнд, эрүүл ахуйг сайжруулахад зориулагдах юм.
- 2010.06.1-2 Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболдын урилгаар БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Вэнь Зябао Монгол Улсад албан ёсны айлчлал хийв. Айлчлалын хүрээнд Монгол Улсын Гадаадын хөрөнгө оруулалтын газар БНХАУ-ын Худалдааны яамны Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих газартай хамтран “Монгол-Хятадын Худалдаа, Эдийн Засгийн Форум”-ыг Улаанбаатар хотноо амжилттай зохион байгууллаа.
- 2010.06.02 Гадаад харилцааны сайд Г.Занданшатар 2010 оны 6 дугаар сарын 2-нд Австралийн Элчин сайд Сэм Геровичийг болон Австралийн Leighton Holdings компаний ТУЗ-ийн дарга Дэвид Мортимэр тэргүүтэй тус компаний ТУЗ-ийн гурван гишүүнийг хүлээн авч уулзав.
- 2010.06.07 Монгол Улсын Ерөнхий сайд, МАХН-ын дарга С.Батболд АНУ-ын Үндэсний Ардчилсан Хүрээлэнгийн (ҮАХ) хөтөлбөрийн захирал, ҮАХ-гийн Индонези дахь төлөөлөгчийн газрын захирал Пол Роуланд, АНУ-ын Конгрессийн Төлөөлөгчдийн танхимын гишүүн асан Самуэль Гейденсон тэргүүтэй ҮАХ-гийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа.
- 2010.06.07 Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд Дэлхийн банкнаас Монгол, Хятад, Солонгос улс хариуцсан захирлаар томилогдсон ноён Клаус Роландыг хүлээн авч уулзлаа. Энэхүү хэлэлцүүлгээр төсвийн тогтвортой байдал, нийгмийн хамгааллын шинэчлэл, банкны салбарын бүтцийн шинэчлэл, бодит салбарыг сэргээн хөгжүүлэх зэрэг чухал асуудлууд хөндөгдөв.
- 2010.06.07 Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд Энэтхэг Улсын Уул уурхай хариуцсан Төрийн нарийн

- бичгийн дарга С.Ш.Наир тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа.
- 2010.06.07 Азид хамтын ажиллагаа, итгэлцлийг бэхжүүлэх зөвлөлгөөний дээд хэмжээний хуралдааны үеэр АХАИБЗ-ий гишүүн орнуудын Гадаад хэргийн сайд нар Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын төлөөлөгчдийн “Евроазийн аюулгүй байдал, эдийн засгийн хамтын ажиллагаа 21 дүгээр зуунд” сэдэвт тусгай хуралдаанд Монгол Улсын Гадаад харилцааны сайд Г.Занданшатар оролцлоо. Уг хуралдаанд Турк, Казахстан, ОХУ, БНХАУ, Япон, Өмнөд Солонгос, Австрали, Тайланд, Афганистан, Киргизстан, Иран, Грек, Литва, Пакистан зэрэг 21 улсын төлөөлөгчид оролцож Евро-Азийн бүс нутаг болон дэлхийн нийтэд тулгарч буй аюулгүй байдал, тогтвортой хөгжил, хар тамхи, терроризм зэрэг асуудлыг хэлэлцлээ.
- 2010.06.07-09 УИХ-ын гишүүн Д.Оюунхорол, Эрүүл мэндийн дэд сайд Ж.Цолмон, УИХ-ын даргын зөвлөх С.Банзрагч нар АНУ-ын Вашингтон хотноо зохион байгуулж буй “Эмэгтэйчүүдийн асуудал -2010” олон улсын бага хуралд оролцов.
- 2010.06.15 Монгол Улсын Гадаад харилцааны яам, Бүгд Найрамдах Литва Улсын Гадаад хэргийн яам хоорондын зөвлөлдөх уулзалт ГХЯ-нд болов. Уулзалтын үеэр талууд хоёр талын болон олон талт хамтын ажиллагааны асуудлаар ярилцаж, цаашид хэрхэн хамтран ажиллах талаар дэлгэрэнгүй санал солилцов. Монгол Улс 2011 оноос Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийг тэргүүлэх үүргийг Литва Улсаас залгамжлан авах бөгөөд энэ асуудлаар санал солилцлоо. Мөн хоёр орны ГХЯ-ны хооронд хамтран ажиллах тухай Санамж бичигт дэд сайд нар гарын үсэг зурав.
- 10.06.16 Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд БНСУ-ын Хөдөлмөрийн сайд Лим Тэ Хи тэргүүтэй БНСУ-ын төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа.
- 2010.06.17 Гадаад харилцааны сайд Г.Занданшатар Германы Техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн Монгол Улс дахь Суурин төлөөлөгчөөр шинээр томилогдсон хатагтай С.Мюллерийг хүлээн авч

- уулзав. Уулзалтын үеэр хоёр тал Берлин хотноо зохион байгуулагддаг “ИТБ” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Монгол Улсыг 2011 онд “Соёлын түнш орон”-оор оролцуулах, мэргэжлийн боловсролын салбарыг хөгжүүлэх зэрэг асуудлаар санал солилцов.
- 2010.06.17 Гадаад харилцааны сайд Г.Занданшатар БНЭУ-ын Элчин сайд Сатбир Сингхийг Итгэмжлэх жуух бичгээ барьсантай нь холбогдуулан хүлээн авч уулзав.
- 2010.06.17 Монгол Улс, Кувейт Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 35 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Гадаад харилцааны сайд Г.Занданшатар болон Кувейтын Эмир Шейх Сабах Аль-Ахмад Аль-Жаббер Аль-Сабахт, Кувейт Улсын Ерөнхий сайдын орлогч бөгөөд Гадаад хэргийн сайд Шейх Мохаммед Сабах Аль-Салем Аль-Сабах нар харилцан цахилгаан утас солилцов.Монгол Улс, Кувейт Улсын хооронд 1975 оны 6 дугаар сарын 17-нд дипломат харилцаа тогтоосон бөгөөд Кувейт Улс нь Булангийн улс орнууд дотроос манай улстай албан ёсны харилцаа тогтоосон анхны орон юм.
- 2010.06.17-18 Парис хотноо болсон Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /ОЕСD/-ын “Евразийн өрсөлдөх чадвар” хөтөлбөрийн Сайд нарын хэмжээний чуулга уулзалтад Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Цогтбаатар тэргүүтэй төлөөлөгчид оролцов.
- 2010.06.21 Манай оронд албан ёсны айлчлал хийж байгаа БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын хорооны дарга, тус орны Намын хорооны нарийн бичгийн дарга Ху Чуньхуа тэргүүтэй төлөөлөгчдийг Монгол Улсын Шадар сайд М.Энхболд хүлээн авч уулзав.

*Хэвлэлд бэлтгэсэн: Б.Сувдмаа, Н.Урангуа, Анандбазар,  
Э.Хулан (ОУСХ-ийн дадлагажигч оюутнууд)*